



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 1/81

Батноров сум

┌ **Согтууруулах ундаа худалдах, түүгээр**
үйлчлэхийг хориглох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багуудын урлаг соёлын наадам болон Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан сумын хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 31, 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Захирамжид дурдсан хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг согтууруулах ундаа худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Бямбацогт), Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (А.Эрдэнэтуяа), Хүнс, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Ч.Чинхүсэл), Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Г.Ганбаяр) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Г.ОТГОНБАЯР